



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/247

Ховд

Зарим үйлчилгээний байгууллагуудад цагийн  
хязгаарлалт тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, “ж”, “л” заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 23 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирус /covid-19/-ийн халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхэлдэг үйлчилгээний төв, дэлгүүр, баар, караоке, ресторан, кафе, зоогийн газруудыг 2020 оны 5 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 10.00 цагаас 22.00 цагийн хооронд үйл ажиллагаа явуулахаар цагийн хуваарийг тогтоосугай.

2.Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нар, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/92, А/122, А/150 дугаар захирамжуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 1057 Zax.A/247.Ch